



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/030/НА-СТА-ТХН

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p> | <p>Санхүү,нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас:260512 Цахим хаяг: enkhdalai.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Я.Марал-эрдэнэ Утас:261628 Цахим хаяг: maralerdeneya@audit.gov.mn</p> <p>Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Ц.Жигдэн Утас: 7000-5401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД
БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.АРИУНТУНГАЛАГ ТАНАА

2025.04.10 № 07/1418
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн нийт санхүүжилт 65.0 сая ам.доллар бөгөөд одоогоор 46.3 сая ам.доллар буюу 71.2 хувийг зарцуулаад байна. Мөн төслийн хэрэгжилтийн хугацаанд нийт 42.8 сая ам.долларын гэрээ байгуулсан нь батлагдсан санхүүжилтийн 65.9 хувийг хамарч байна.

Төслийн хүрээнд 7 сургууль, 14 цэцэрлэгийн барилга угсралтын ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 6 сургууль, 13 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулснаар ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоо 3400-аар, цэцэрлэгийн орны тоо 2225-аар нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Түүнчлэн төслийн санхүүжилтээр ерөнхий боловсролын 47 сургуулийн 590 анги, танхимд нийт 5,165,080.9 мянган төгрөгийн өртөг бүхий сурагчийн ширээ, сандал болон иж бүрэн тавилга, 135 ангид 3,084,567.0 мянган төгрөгийн өртөг бүхий цахим ангийн иж бүрэн техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлсэн. Үүний үр дүнд нийт 21,322 сурагчийн сургалтын орчин сайжирсан бодит үр дүн гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд 2018 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр байгуулсан L3594-MON дугаартай 50.0 сая ам.долларын зээлийн гэрээний хэрэгжилтийн хугацааг 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дуусгахаар дахин сунгасан байна.

Мөн Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдөр 15.0 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийн L4438-MON дугаартай зээлийн гэрээг 2027 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хэрэгжүүлж дуусгахаар нэмж байгуулсан байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн тайлант оны төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 арга хэмжээнээс 77.8 хувийг хэрэгжүүлснээр тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант он: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|--------------------------|---------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 82,583,062,969.43 | 102,188,869,728.89 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,045,305,885.99 | 11,748,478,688.78 |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 2,045,305,885.99 | 11,748,478,688.78 |
| 31210 | Төгрөг | 1,730,614,991.92 | 665,697,184.74 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,730,614,991.92 | 665,697,184.74 |
| 31220 | Гадаад валют | 314,690,894.07 | 11,082,781,504.04 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 314,690,894.07 | 11,082,781,504.04 |
| 33 | АВЛАГА | - | 109,441.52 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 109,441.52 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 131,025,338.54 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 131,025,338.54 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8,046,400.00 | 7,958,400.00 |
| 35400 | Хангамжийн материал | 8,046,400.00 | 7,958,400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 374,000.00 | 374,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,505,400.00 | 3,417,400.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,167,000.00 | 4,167,000.00 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 80,398,685,344.90 | 90,432,323,198.59 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө | 80,398,685,344.90 | 90,432,323,198.59 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 33,785,765.56 | 27,807,187.31 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 33,785,765.56 | 27,807,187.31 |
| 39200 | Биет хөрөнгө | 33,626,383.84 | 27,807,187.31 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 121,300,908.00 | 86,720,198.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (101,317,688.33) | (69,428,803.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,868,700.00 | 22,807,310.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,225,535.83) | (12,291,516.74) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 159,381.72 | - |
| 39301 | Программ хангамж | 8,250,000.00 | 8,250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,090,618.28) | (8,250,000.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 82,616,848,734.99 | 102,216,676,916.20 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 8,841,443,144.92 | 5,215,828,888.18 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 8,841,443,144.92 | 5,215,828,888.18 |
| 41300 | Өглөг | 8,841,443,144.92 | 5,215,828,888.18 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 73,775,405,590.07 | 97,000,848,028.02 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 73,775,405,590.07 | 97,000,848,028.02 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 73,775,405,590.07 | 97,000,848,028.02 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 49,183,095,949.14 | 73,775,405,590.07 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 24,592,309,640.93 | 23,225,442,437.95 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 82,616,848,734.99 | 102,216,676,916.20 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант он: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|--|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 29,022,108,142.00 | 38,951,660,412.56 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 29,022,108,142.00 | 38,951,660,412.56 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 29,022,108,142.00 | 38,951,660,412.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 29,005,738,806.39 | 38,931,760,412.56 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 28,829,976,721.29 | 38,931,760,412.56 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 175,762,085.10 | - |
| 120009 | Бусад орлого | 16,369,335.61 | 19,900,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,320,028,298.29 | 15,772,789,666.66 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,320,028,298.29 | 15,772,789,666.66 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,320,028,298.29 | 15,772,789,666.66 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 487,321,647.05 | 528,417,157.89 |
| 210101 | Үндсэн цалин | 487,321,647.05 | 528,417,157.89 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,915,205.88 | 66,733,245.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,422,340.00 | 45,502,837.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,873,216.47 | 5,295,407.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,898,573.18 | 2,991,175.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 974,643.29 | 1,612,224.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,746,432.94 | 11,331,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 85,874,630.00 | 92,346,127.00 |
| 210304 | Байрны түрээс | 85,874,630.00 | 92,346,127.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,905,493.79 | 17,615,667.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,043,693.00 | 9,874,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 620,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,241,800.79 | 7,741,667.97 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,149,000.00 | 1,953,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,149,000.00 | 1,953,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 43,088,709.27 | 46,487,150.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 41,998,109.27 | 46,487,150.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,090,600.00 | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 792,612,407.30 | 798,265,543.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 753,240,184.30 | 745,264,821.21 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 33,000,000.00 | 33,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 174,048.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,198,175.00 | 19,576,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 424,722.07 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,835,161,205.00 | 14,220,971,275.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 880,322,359.00 | 13,088,188,323.53 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,904,852,066.00 | 1,126,967,784.60 |

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|------------|--|--------------------------|--------------------------|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 49,986,780.00 | 5,815,167.34 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 24,702,079,843.71 | 23,178,870,745.90 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | 61,736,947.84 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 61,736,947.84 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 109,770,202.78 | 15,165,255.79 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 109,077,643.71 | 521,400.91 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 692,559.07 | 14,643,854.88 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 24,592,309,640.93 | 23,225,442,437.95 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант он: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 7,757,137,684.57 | 18,803,321,094.73 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,757,137,684.57 | 18,803,321,094.73 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,757,137,684.57 | 18,803,321,094.73 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,740,768,348.96 | 18,783,421,094.73 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 7,740,768,348.96 | 18,783,421,094.73 |
| 120009 | Бусад орлого | 16,369,335.61 | 19,900,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,781,555,026.02 | 3,331,302,776.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,781,555,026.02 | 3,331,302,776.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,781,555,026.02 | 3,331,302,776.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 487,555,147.05 | 528,655,818.35 |
| 210101 | Үндсэн цалин | 487,555,147.05 | 528,655,818.35 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,915,205.88 | 66,604,026.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,422,340.00 | 45,373,618.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,873,216.47 | 5,295,407.94 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,898,573.18 | 2,991,175.46 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 974,643.29 | 1,612,224.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,746,432.94 | 11,331,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 85,874,630.00 | 92,346,127.00 |
| 210304 | Байрны түрээс | 85,874,630.00 | 92,346,127.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,143,293.79 | 21,691,667.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,394,693.00 | 10,850,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,866,800.79 | 7,741,667.97 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,881,800.00 | 3,100,000.00 |
| 2105 | Нормативд зардал | 4,477,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,477,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,873,400.00 | 2,944,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,273,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,600,400.00 | 2,944,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 42,547,800.00 | 46,487,150.00 |

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|---------------------------|---------------------------|
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 42,547,800.00 | 46,487,150.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,066,630,169.30 | 2,572,089,886.72 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,062,605,421.30 | 2,569,213,164.65 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 794,048.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,230,700.00 | 2,452,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 424,722.07 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,538,380.00 | 484,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,538,380.00 | 399,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 85,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 4,975,582,658.55 | 15,472,018,318.58 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | - | - |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 4,879,527,610.22 | 5,815,938,609.04 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,879,527,610.22 | 5,815,938,609.04 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,879,527,610.22 | 5,815,938,609.04 |
| 220001 | Барилга байгууламж | 4,870,557,682.22 | 5,461,733,106.04 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 354,205,503.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,969,928.00 | - |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (4,879,527,610.22) | (5,815,938,609.04) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (692,559.07) | 47,093,093.25 |
| 14 | Бусад эх үүсвэр | - | 61,736,947.82 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | - | 61,736,947.82 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 692,559.07 | 14,643,854.57 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 692,559.07 | 14,643,854.57 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 95,362,489.26 | 9,703,172,802.79 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,949,943,396.73 | 2,045,305,885.99 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,045,305,885.99 | 11,748,478,688.78 |

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант он: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------|--|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 49,183,095,949.14 | 49,183,095,949.14 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | 49,183,095,949.14 | 49,183,095,949.14 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | - | 24,592,309,640.93 | 24,592,309,640.93 |
| 5 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 73,775,405,590.07 | 73,775,405,590.07 |
| 6 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | 73,775,405,590.07 | 73,775,405,590.07 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | - | 23,225,442,437.95 | 23,225,442,437.95 |
| 9 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 97,000,848,028.02 | 97,000,848,028.02 |

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант он: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|-------------------|-------------------|------------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 31,351,000,000.00 | 29,277,392,648.20 | 2,073,607,351.80 | 93.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,350,000,000.00 | 3,313,114,721.31 | 36,885,278.69 | 98.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,350,000,000.00 | 3,313,114,721.31 | 36,885,278.69 | 98.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 529,000,000.00 | 528,655,818.35 | 344,181.65 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 529,000,000.00 | 528,655,818.35 | 344,181.65 | 99.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,639,600.00 | 66,604,026.11 | 1,035,573.89 | 98.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,809,300.00 | 45,373,618.42 | 435,681.58 | 99.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,665,800.00 | 5,295,407.94 | 370,392.06 | 93.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,000,000.00 | 2,991,175.46 | 8,824.54 | 99.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,832,900.00 | 1,612,224.29 | 220,675.71 | 88.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,331,600.00 | 11,331,600.00 | 0.00 | 100 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 93,000,000.00 | 92,346,127.00 | 653,873.00 | 99.3 |
| 210304 | Байрны түрээс | 93,000,000.00 | 92,346,127.00 | 653,873.00 | 99.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,850,000.00 | 21,691,667.97 | 158,332.03 | 99.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,850,000.00 | 10,850,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,900,000.00 | 7,741,667.97 | 158,332.03 | 98.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,100,000.00 | 3,100,000.00 | - | 100.0 |

Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төслийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|--|--------------------------|--------------------------|---------------------------|--------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,944,000.00 | 2,944,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,944,000.00 | 2,944,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 48,230,500.00 | 46,487,150.00 | 1,743,350.00 | 96.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 48,230,500.00 | 46,487,150.00 | 1,743,350.00 | 96.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,586,580,900.00 | 2,553,901,831.88 | 32,679,068.12 | 98.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,579,826,900.00 | 2,551,025,109.81 | 28,801,790.19 | 98.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,254,000.00 | 2,452,000.00 | 3,802,000.00 | 39.2 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000.00 | 424,722.07 | 75,277.93 | 84.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 755,000.00 | 484,100.00 | 270,900.00 | 64.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 399,100.00 | 100,900.00 | 79.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 255,000.00 | 85,000.00 | 170,000.00 | 33.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 28,001,000,000.00 | 25,964,277,926.89 | 2,036,722,073.11 | 92.7 |
| 220001 | Барилга байгууламж | 17,001,000,000.00 | 16,481,825,868.20 | 519,174,131.80 | 96.9 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 11,000,000,000.00 | 9,482,452,058.69 | 1,517,547,941.31 | 86.2 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 31,351,000,000.00 | 38,931,760,412.58 | (7,580,760,412.58) | 124.2 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 31,351,000,000.00 | 38,931,760,412.58 | (7,580,760,412.58) | 124.2 |
| 350004 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 31,351,000,000.00 | 38,931,760,412.58 | (7,580,760,412.58) | 124.2 |
| | Балансын тохируулга | | 48,805,038.41 | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 2,045,305,885.99 | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 11,748,478,688.78 | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 13 | 8 | 5 | 61.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | - | 1 | -100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 8 | 4 | 66.7 |

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 132,673.6 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг таслан зогсоох, арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|----------------|--------------------------------------|-----|---|-----|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант хугацаанд төслийн санхүүжилтээр баригдсан барилга угсралтын ажил, зөвлөх үйлчилгээний зарим гүйлгээг цахим “төлбөрийн баримт”-аар баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | 1 | 88,926.5 | | | 1 | 88,926.5 | | | | | | |
| 2 | Нийлүүлэгчээс 6 сургууль, 4 цэцэрлэгт нийлүүлсэн зарим барааны өртгийг зарлагын баримтад гэрээний дүнгээс зөрүүтэй дүнгээр захиалагчид хүргүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь гэрээний худалдан авалт, нийлүүлэлтэд хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна. | 1 | 39,459.0 | | | 1 | 39,459.0 | | | | | | |
| 3 | Төслийн санхүүжилтээр баригдсан зарим сургууль, цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын өртөг дээр барилгын материалын үнийн өсөлтийг нэмж, гүйцэтгэгчтэй гэрээг шинээр байгуулж, зөрүүг төслөөс бүрэн санхүүжүүлсэн. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүртгэлд үлдэгдэлтэй дээрх үнийн өсөлтийн зөрүүг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| 4 | "Бодь электроникс" ХХК-тай ам.доллараар байгуулсан гэрээний төлбөр шилжүүлсэн болон цахим тоног, төхөөрөмжийг ашиглагчид нийлүүлсэн өдрийн ам.долларын валютын ханшнаас үүссэн зөрүүг бүртгэлд тусгаагүй байна. | 1 | 4,288.1 | | | | | 1 | 4,288.1 | | | | |
| | Дүн | 4 | 132,673.6 | | | 3 | 128,385.5 | 1 | 4,288.1 | | | | |